



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 2 сарын 24 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52.1.3 дахь заалт, 52.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2013 оны 7 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "4.1.10 Цахим тендер шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн аливаа тодруулгын хариу албан бичгийг цахим системийн тендерийн баримт бичиг хэсэгт олон нийтэд эх сурвалжийг дурдалгүйгээр нийтэлнэ." гэж, 8 дугаар зүйлд "8.5 Цахим тендерт оролцогчид захиалагчийн уг журмын 4.1.10-т заасны дагуу нийтэлсэн тодруулгын дагуу тендерээ бэлтгэх үүргийг хүлээнэ." гэж тус тус нэмсүгэй.

Хоёр. Сангийн сайдын 2013 оны 7 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын 4.1.9-д "...татвар төлөлт, санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг шалгана." гэснийг "...татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана." 6.2-т "...22.2-т заалтад үндэслэсэн байх бөгөөд 20,000.00 /хорин мянга/...", гэснийг "...22.2-т хэсэгт үндэслэсэн байх бөгөөд 50,000.00 /тавин мянга/..." гэж өөрчилсүгэй.

Гурав. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/, Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/-т тус тус даалгасугай.

САЙД



Ч.УЛААН

0000086